



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/547

Арвайхээр сум


Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 10, 11 дүгээр багийн авто зам, Дэлгэрэх голын голдирол, Политехник коллеж төмөр бетон гүүр, төв бараан захын баруун талын төмөр бетон гүүрийн засварын ажил, авто замын нөхөөс, авто замд гагнаас хийх (зун) засварын ажлыг байнгын ашиглалтад авах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг авто замын барилга байгууламжийг ашиглалтад авах комиссын дарга (Б.Мөнхбат)-д даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дугаар
сарын 07-ны өдрийн 18542 дугаар
захирамжийн хавсралт

**АВТО ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
АВАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Ц.Алтан-Эрдэнэ (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч)

Ц.Нэргүй (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга, Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч)

Т.Мөнхбаян (Арвайхээр сумын Архитектор)

Гүйцэтгэгч аж ахуй нэгжийн төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Б.Цогтбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Авто замын хяналтын улсын байцаагч)

-оОо-